

БАТАЛГААЖУУЛАЛТ :  
ЖИНСТ СУМЫН ЗАСАГ ДАРГА  
..... Р.БАТЖАРГАЛ  
2024 оны 04 дугаар сарын 25



БАТАЛГААЖУУЛАЛТ:  
БОС-А3 ХХК  
ГҮЙЦЭТГЭГЧ ..... А.ЗОЛЗАЯА  
2024 оны 07 дугаар сарын 15

**ЖИНСТ СУМЫН СОЁЛЫН ТӨВД ТОНОГ  
ТӨХӨӨРӨМЖ НИЙЛҮҮЛЭХ АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

Дугаар № 7

2024 оны 04 сарын 25

Бодь

**Нэг. Гэрээний зорилго**

1.1.Нэг талаас Жинст сумын Засаг даргын Тамгын газрын дарга З.Цэрэндорж /цаашид захиалагч гэх/ нөгөө талаас Соёлын төвд тоног төхөөрөмж нийлүүлэх /цаашид гүйцэтгэгч гэх/ А.Золзаяа нар дараах зүйлийг харилцан тохиролцож 2024 оны 04 дугаар сарын 25 өдрөөс эхлэн энэхүү гэрээг байгуулав.

1.2.Монгол Улсын иргэний хууль болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу олон нийтийн оролцоотойгоор бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбогдон захиалагч, нийлүүлэгчийн үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

1.3.Захиалагч байгууллага болох Жинст сумын СОЁЛЫН ТӨВД ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ НИЙЛҮҮЛЭХ ажлыг гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгүүлэгчийн саналыг хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтын нийт гүйцэтгэл болно. 44.129,000 /Дөчин дөрвөн сая нэг зуун хорин есөн мянган/ төгрөгийг СОЁЛЫН ТӨВД ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ НИЙЛҮҮЛЭХ ажлыг борлуулсан үнэ төлбөрөөс санхүүжүүлнэ.

1.4.Захиалагч нь гэрээгээр гүйцэтгэх ажлын зураг дуусч, ажил эхлэх зөвшөөрөл гарсны дараа гүйцэтгэгчид ажил эхлэх мэдэгдлийг албан бичгээр өгч, ажлын талбайг хүлээлгэж өгнө.

1.5.Гүйцэтгэгч нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүрэг болох СОЁЛЫН ТӨВД ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ НИЙЛҮҮЛЭХ ажлыг захиалагч төлбөрийг хэсэгчилэн шилжүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор гүйцэтгэнэ.

**Хоёр. Захиалагчийн эрх үүрэг**

2.1.СОЁЛЫН ТӨВД ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ НИЙЛҮҮЛЭХ ажлыг төсөл болон зурагт заасан стандартын шаардлага хангаагүй гүйцэтгэсэн тохиолдолд хүлээн авахгүй буцаах

2.2.Нийлүүлэгчийн нэхэмжлэлээр төлбөр тооцоог гэрээнд заасан хуваариар РД:5534623 регистрийн дугаартай БОС-А3 худалдаа хөгжлийн банк дахь 413053160 дансанд шилжүүлэх.

2.4.Хийж гүйцэтгэх ажлын хуваарийг захиалагчид гарган танилцуулна.

Ажлыг гүйцэтгэх хуваарь

д/д	Хийгдэх ажил	Гүйцэтгэл %	Санхүүжилт
1	Урьдчилгаа		
2	Явцын гүйцэтгэлээр		
3	Ажлыг дуусахад	100%	44.129,000
4	Нийт дүн	100%	44.129,000

2.5.Захиалагч ажлын эхлэл, явц, гүйцэтгэлд хяналт тавих, ажлын хэсгийг томилж ажиллуулна.

2.6.Гүйцэтгэгч нь захиалагчийн захиалсан ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэж чадаагүй тохиолдолд хугацаа хожимдсон хоног тутамд 0,5 хувийн алданги тооцно.

2.7.Захиалагч нь барааг 100 хувь нийлүүлснээс хойш санхүүжилтийг ажлын 5 хоногт багтаан 100 хувь олгоно.

Гурав. Гүйцэтгэгчийн хүлээх үүрэг

3.1.СОЁЛЫН ТӨВД ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ НИЙЛҮҮЛЭХ ажил нь стандарт чанарын шаардлага хангасан байна.

3.2.Бүтээгдэхүүн нийлүүлэлтийн тээврийн зардлыг бүрэн хариуцна.

3.3.Ажил үүрэг гүйцэтгэсэн тухай санхүүгийн анхан шатны баримтыг үнэн зөв бүрдүүлэн нярав болон нягтлан бодогчид хүлээлгэн өгч ажлын гүйцэтгэлийн тайланг ажил гүйцэтгэсний дараа ажлын 5 хоногт багтаан Захиалагчид гарган өгч санхүүгийн тооцоо хийнэ.

3.4.Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно.

Үүнд:

- ✓ Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл, үнэлгээний хорооны санал
- ✓ Бусад шаардлагатай баримт бичиг
- ✓ Гүйцэтгэгчийн ирүүлсэн санал
- ✓ Гэрээний ерөнхий нөхцөл
- ✓ Ажлын зураг, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт
- ✓ Гүйцэтгэгчийн ирүүлсэн үйл ажиллагааны хуваарь

- ✓ Санхүүжилтын хуваарь
- ✓ Чадамжийн мэдээлэл

3.5. Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

3.6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх үүрэг хүлээнэ.

3.7. Нийлүүлэгч нь энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдлыг гарсан даруй арилгах үүрэг хүлээнэ.

3.8. Захиалагч нь гэрээний дагуу хийж гүйцэтгэсэн ажил болон зөрчил гологдлол гарсан даруй арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг хүлээнэ.

3.9. Гүйцэтгэгч нь энэхүү ажил эхлэх зөвшөөрөл хүлээн авсан өдрөөс эхлэн гэрээт ажил эхэлсэнээр тооцож, ажил гүйцэтгэх календарчилсан график төлөвлөгөөний дагуу бүрэн гүйцэтгэж дуусгана.

3.10. Дараах тохиолдлууд нь ажлын гүйцэтгэлийн хугацаа хойшлох үндсэн шалтгаан болно. Үүнд:

- ✓ Захиалагч тал заасан хугацаанд ажил эхлэх нөхцлийг бүрдүүлж өгөөгүй
- ✓ Захиалагч тал гэрээнд заагдсан хугацаанд явцын төлбөр төлөөгүй
- ✓ Гүйцэтгэгч тал гэм буруугүй үйлдлээс болж хойшилсон аливаа нөхцөл байдал бий болсон

3.11. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон биечлэн уулзаж харилцана.

3.12. Гүйцэтгэгч нь энэхүү гэрээний дагуу ажлыг гүйцэтгэхдээ биет байдлын болон эрхийн доголдолгүй, сайн чанарын материалаар бүтээцийн даацын хэмжээнд тохируулан мэргэжлийн өндөр түвшинд, Монгол Улсын стандартын шаардлага, гэрээний заалтуудад нийцүүлэн чанартай гүйцэтгэнэ.

3.13. Гүйцэтгэгч нь энэхүү гэрээт *СОЁЛЫН ТӨВД ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ НИЙЛҮҮЛЭХ* ажилд хэрэглэх, тоног төхөөрөмжийг захиалагчид урьдчилан танилцуулж, батлуулсаны дараа угсран суурилуулах үүрэгтэй бөгөөд захиалагчийн зөвшөөрөлгүйгээр угсран суурилуулсан материал, тоног төхөөрөмжийг захиалагч шаардан үнэ төлбөргүйгээр гүйцэтгэгчээр солиулах бүрэн эрхтэй. Энэхүү заалт зөрчсөнөөс үүсэх хугацааны алдагдал, өөрчлөлт нь ажил гүйцэтгэлийн хугацаа хойшлох шалтгаанд тооцогдохгүй.


3.14. Гүйцэтгэгч нь ажил эхлэх мэдэгдэл хүлээн авсан өдрөөс эхлэн гэрээний заалтууд, батлагдсан зургийн дагуу гэрээт ажлыг хангалттай хүн хүч, техник хүч, техник тоног төхөөрөмжтэйгээр талуудын тохиролцсон төлөвлөгөөний дагуу шуурхай гүйцэтгэж эхэлнэ.

3.15. Ажил гүйцэтгэх явцад гүйцэтгэгчийн зүгээс тодруулга, өөрчлөлт, шийдвэр болон заавар шаардлагатай болсон тохиолдолд энэ тухай гүйцэтгэгч нь ажлын 7 хоногоос багагүй хугацааны өмнө бичгээр мэдэгдэх бөгөөд энэ хугацаанд мэдэгдээгүйн улмаас үүсэх хугацааны алдагдал, өөрчлөлт нь ажил гүйцэтгэлийн хугацаа хойшлох шалтгаанд тооцогдохгүй.

3.16. Захиалагчийн хяналтын зардалд төсөвт өртгийн 0 /хувьтай/ тэнцэх төгрөгийг орон нутгийн төсөвт суутган авч үлдэнэ.

3.17. Бараа бүтээгдэхүүн нийлүүлснээс хойш хэрэглэгчээс шалтгаалаагүй эвдрэл гэмтлийг 1 жилийн хугацаанд хариуцна.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ :  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГА /11/ З.ЦЭРЭНДОРЖ  
2024 оны 04 дугаар сарын 25



ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ :  
БОС-АЗ ХХК  
ГҮЙЦЭТГЭГЧ ..... А.ЗОЛЗАЯА  
2024 оны 04 дугаар сарын 25

